

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |           |      |
|------|---|-----------|------|
| 467. | Монгол Улсын Их Хурлын<br>дэд даргыг сонгох тухай | Дугаар 09 | 1893 |
| 468. | Зарим Байнгын хорооны дарга<br>нарыг сонгох тухай | Дугаар 10 | 1894 |
| 469. | Монгол Улсын Ерөнхий сайдыг<br>томилох тухай      | Дугаар 11 | 1894 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |  |            |      |
|------|--|------------|------|
| 470. | Нэрэмжит шагнал олгох<br>журам батлах тухай  | Дугаар 204 | 1895 |
| 471. | “100 мянган айлын орон сууц”<br>хөтөлбөрт хамрагдах орон сууцны<br>жагсаалт батлах тухай | Дугаар 206 | 1898 |
| 472. | Гэр хорооллын иргэдийн усны<br>үйлчилгээний төлбөрийг<br>хөнгөлөх тухай                  | Дугаар 209 | 1902 |
| 473. | Хуулийн хэрэгжилтийг хангах<br>зарим арга хэмжээний тухай                                | Дугаар 210 | 1903 |
| 474. | Дүрэмд нэмэлт, өөрчлөлт<br>оруулах тухай   | Дугаар 212 | 1903 |
| 475. | Зарлагын хязгаарыг батлах тухай  | Дугаар 214 | 1904 |
| 476. | Монгол Улсын иргэнд давуу эрхийн<br>хувьцаа эзэмшигүүлэх тухай                           | Дугаар 218 | 1911 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Их Хурлын дэд  
даргыг сонгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх  
хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1,

12.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын дэд даргаар МАХН-МУАН-ын “Шударга Ёс” эвслийн бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Чүлтэмийн Улааныг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 08 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар  
хот

**Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Зангадын Баяансэлэнгэ, Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Шаравдоржийн Түвшэндорж нарыг тус тус сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 08 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1. Монгол Улсын Ерөнхий сайдыар Норовын Алтанхуягийг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2012 оны 6 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 204

Улаанбаатар  
хот

**Нэрэмжит шагнал олгох журам батлах тухай**

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Академич Б.Ширэндэвийн нэрэмжит шагнал бий болгосугай.

2. Академич Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Б.Ширэндэв нарын нэрэмжит шагнал олгох журмыг 1 дүгээр, нэрэмжит шагналын энгэрийн тэмдэг, үнэмлэхийн тодорхойлолтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Шагнал олгохтой холбогдон гарах зардлыг боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Д.Хаянхярваад даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Академич Б.Ринчений нэрэмжит шагнал бий болгох тухай” Засгийн газрын 1990 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 171 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн "...5 жил тутамд 1 удаа 5 хүртэл хүнд олгож байхаар тогтоосугай” гэсэн хэсэг, “Б.Ринчений нэрэмжит шагнал эрхлэх комиссын байнгын гишүүд, дурмийг батлах тухай” Засгийн газрын 1992 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 47 дугаар тогтоол, “Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит шагнал бий болгох тухай” Засгийн газрын 1993 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 146 дугаар тогтоолын 2, 3 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Ё.ОТГОНБАЯР**

Засгийн газрын 2012 оны 204 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

НЭРЭМЖИТ ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Академич Б.Ринчен Ц.Дамдансүрэн, Б.Ширэндэв нарын нэрэмжит шагнал олгоход энэхүү журмыг баримтална.

2. Эрдэмтэн, судлаач, шинжлэх ухаан, технологийн салбарын зүтгэлтэнд их эрдэмтдийн нэрэмжит дараахь шагналыг олгоно:

2.1. Монгол судлалын салбарт эрдэм шинжилгээний шилдэг бүтээл туурвисан, монгол түүрэгтны соёлын өв уламжлалыг сэргээн баяжуулах үйлсэд дорвitoй хувь нэмэр оруулсан, дэлхийн соёл, шинжлэх ухаан, урлаг, уран зохиолын сонгодог бүтээлийг монгол хэл рүү орчуулсан, монголын утга зохиол, соёлын үнэт дурсгал, эх бичгийг дэлхий нийтийн хүртээл болгоход онцгой хувь нэмэр оруулсан Монгол Улсын болон гадаадын 5 хүртэл иргэнд 5 жилд нэг удаа Академич Б.Ринченгийн нэрэмжит;

2.2. Монгол хэл, монголын утга зохиол болон дорно дахины, түүний дотор төвд судлалын чиглэлээр эрдэм шинжилгээний шилдэг бүтээл туурвиж, дорвitoй хувь нэмэр оруулсан Монгол Улсын болон гадаадын 3 хүртэл иргэнд 3 жилд нэг удаа Академич Ц.Дамдансүрэнгийн нэрэмжит;

2.3. Шинжлэх ухаан, технологийн салбарын хөгжил, эрдэм шинжилгээний байгууллагын менежментийг боловсронгуй болгох, шинэ салбар судлалыг хөгжүүлэх үйлсэд онцгой үүрэг гүйцэтгэсэн тус салбарын зүтгэлтэн 2 хүртэл иргэнд 3 жилд нэг удаа Академич Б.Ширэндэвийн нэрэмжит.

3. Энэ журмын 2.3-т заасан салбарын зүтгэлтэн гэдэгт Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл”, “Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл”-д хамаарах удирдах албан хаагч хамаарна.

4. Их эрдэмтдийн нэрэмжит шагнал олгох хороодыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгуулж, ахлах бөгөөд хороо тус бүр 11-ээс доошгүй гишүүнтэй байна.

5. Нэрэмжит шагналд эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллага, уран бүтээлийн холбоод, хамт олон нэр дэвшүүлнэ.



6. Шагналд нэр дэвшигчийн туурвисан шилдэг бүтээл нь хэвлэгдэж олны хүртээл болсон байна.

7. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь шагналд нэр дэвшигчийн материал хүлээн авах хугацааг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 1 жилийн өмнө нийтэд зарлана. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь материалыг хүлээн авч, холбогдох мэргэжлийн байгууллага, хүмүүсийн саналыг тусган хорооны хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

8. Шагнал олгох хорооны хурал нь нийт гишүүдийн 75 хувь ирснээр хүчинтэйд тооцогдох бөгөөд шагнал олгох асуудлыг хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

9. Нэрэмжит шагнал хүртэгчид тухайн их эрдэмтний дүрийг товайлgon хийсэн энгэрийн тэмдгийг, үнэмлэхийн хамт олгоно. Нэрэмжит шагналыг 5.0 (таван сая) төгрөг дагалдана.

10. Б.Ринченгийн нэрэмжит шагналыг олон улсын Монголч эрдэмтдийн их хурлын үеэр, Ц.Дамдинсүрэн, Б.Ширэндэвийн нэрэмжит шагналыг шинжлэх ухааны ажилтны өдөр (жил бүрийн 11 дүгээр сарын 4 дэх ням гариг) гардуулна. Хамтын бүтээлийн зохиогч бүрт энгэрийн тэмдэг, үнэмлэх олгох бөгөөд мөнгөн шагналыг хамтран туурвисан хүмүүсийн дунд олгоно.

11. Шинжлэх ухааны академи нь их эрдэмтдийн нэрэмжит шагнал хүртэгчдийн талаархи мэдээллээр сан бүрдүүлж хадгална.

Засгийн газрын 2012 оны 204 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

**НЭРЭМЖИТ ШАГНАЛЫН ЭНГЭРИЙН ТЭМДЭГ,  
ҮНЭМЛЭХИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Нэг. Энгэрийн тэмдэг

Нэрэмжит шагнал хүртэгчид олгох энгэрийн тэмдэг нь жижиг цагиргаар өөр хоорондоо холбогдсон хоёр хэсгээс бүрдэнэ. Дээд хэсгийг 25 мм урт, 9 мм өргөнтэй тэгш өнцөгтийн доод хэсэгт 7 мм өндөртэй адил хажуут гурвалжин хошууг залган хийх бөгөөд Монгол Улсын төрийн далбааны өнгөтэй байна. Тэмдгийн доод хэсэг нь 34 мм-ийн голчтой дугуй дээр их эрдэмтний цээж дүрийг товайлгон дурсэлж, дор нь кирилл үсгээр “Академич Б.Ринчен”, “Академич Ц.Дамдинсүрэн”, “Академич Б.Ширэндэв”

гэж тус тус бичсэн байна. Дээд хэсгийн зузаан нь 1.5 мм, доод хэсгийнх нь 2.5 мм байна. Тэмдгийг мөнгөлөг өнгийн металлаар хийнэ.

Хоёр. Үнэмлэх

Үнэмлэх нь 100 мм x 150 мм-ийн хэмжээтэй, улаан өнгийн материалаар хийсэн зээлөвч бүхий хавтастай, хавтасны нүүрэн дээр “Нэрэмжит шагналын үнэмлэх” гэж монгол бичгээр бичсэн байна.

Үнэмлэхийн хавтасны дотор тал нь мөнгөлөг өнгтэй байх бөгөөд алтан шаргал өнгийн түмэн насан хээгээр хүрээлсэн байна. Хавтасны дотор талын эхний нүүрэнд “Үнэмлэх”, “Дугаар...” гэж, дараагийн нүүрэн дээр:

“Хүндэт.....Танд Монгол судлалын салбарт шилдэг бүтээл туурвиж, Монгол туургатны соёлын өв уламжлалыг сэргээн баяжуулах (дэлхийн соёл, шинжлэх ухаан, уран зохиолын бүтээлийг орчуулан олон түмний хүртээл болгох), (Монголын утга зохиол, соёлын үнэт дурсгал, эх бичгийг дэлхий нийтийн хүртээл болгох) үйлсэд оруулсан хувь нэмрийг үнэлж, Академич Б.Ринченгийн нэрэмжит шагнал олгов.”, “Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд.....(гарын үсэг), ...оны...дугаар сарын...ны өдөр” гэж,

“Хүндэт.....Танд монгол хэл, утга зохиол, дорно дахины судлалын чиглэлээр эрдэм шинжилгээний шилдэг бүтээл туурвисан тул Академич Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит шагнал олгов.”, “Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд.....(гарын үсэг), ...оны...дугаар сарын...ны өдөр” гэж,

“Хүндэт.....Танд Монгол Улсын шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлст оруулсан хувь нэмрийг тань өндөрөөр үнэлж, Академич Б.Ширэндэвийн нэрэмжит шагнал олгов.”, “Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд.....(гарын үсэг), ...оны...дугаар сарын...ны өдөр” гэж, тус тус бичсэн байна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар  
хот

**“100 мянган айлын орон сууц” хетэлбөрт хамрагдах  
орон сууцны жагсаалт батлах тухай**

Орон сууцны тухай хуулийн 4.1.3, 11.1.1-д заасныг үндэслэн, Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоол болон Засгийн газрын үйл



ажиллагааны хөтөлбөрийн 2.4.7 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрт хамрагдаж  
Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв болон аймгийн төвд баригдах орон  
сууцны барилга, хотхон, хорооллын III ээлжийн жагсаалтыг хавсралт  
ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан орон сууцны барилга,  
хотхон, хорооллыг барьж байгуулах хөрөнгө оруулагч, аж ахуйн  
нэгжүүдтэй хэрэгжилтийг хангуулах гэрээ байгуулж, хамтран ажиллахыг  
Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, аймаг,  
нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг  
Орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх Үндэсний хороо (М.Энхболд)-нд  
даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**М.ЭНХБОЛД**

Засгийн газрын 2012 оны 206 дугаар  
тогтоолын хавсралт

**“100 МЯНГАН АЙЛЫН ОРОН СУУЦ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАЖ  
УЛААНБААТАР ХОТ, БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ БОЛОН АЙМГИЙН  
ТӨВД БАРИГДАХ ОРОН СУУЦНЫ БАРИЛГА, ХОТХОН,  
ХОРООЛЛЫН III ЭЭЛЖИЙН ЖАГСААЛТ**

№	Төслийн нэр	Байршил	Нийт айлын сууцны тоо	Төслийг хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага
<b>УЛААНБААТАР ХОТ</b>				
<b>БАЯНГОЛ ДҮҮРЭГ</b>				
1	“Алтай” орон сууцны хотхон	БГД, 1 дүгээр хороо	132	“Тайгам-Алтай” ХХК
2	“Залуус” хотхоны 60 айлын орон сууцны барилга	БГД, 9 дүгээр хороо	32	“ЖСК” ХХК
3	МООНРТ-ийн ажилчдын үйлчилгээтэй, орон сууцны барилга	БГД, 11 дүгээр хороо	144	МООНРТ, “Харгант цамхаг групп” ХХК
4	“Хaan суудал” ХХК-ийн орон сууцны барилга	БГД, 18 дугаар хороо	272	“Хaan суудал” ХХК

5	НОБГ-ын ажилчдын 120 айлын орон сууцны барилга	БГД, 20 дугаар хороо	120	Нийслэлийн Онцгой байдлын газар
<b>БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ</b>				
6	“Зүмбэр орд” ХХК-ийн орон сууцны барилга	БЗД, 5 дугаар хороо	36	“Зүмбэр орд” ХХК
7	Гаалийн ажилчдын 72 айлын орон сууцны барилга	БЗД, 5 дугаар хороо	72	Замын-Үүдийн Гаалийн газар, “Их модун” ХХК
8	“Чинбаа инвест” ХХК-ийн 35 айлын орон сууцны барилга	БЗД, 6 дугаар хороо	35	“Чинбаа инвест” ХХК
9	“Хүслийн өргөө” орон сууцны барилга	БЗД, 25 дугаар хороо	195	“Азийн ирээдүй” ХХК
10	60 хүүхдийн цэцэрлэгтэй, 53 айлын орон сууцны барилга	БЗД, 25 дугаар хороо	53	“Номгон очир” ХХК
<b>СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ</b>				
11	“ЮП” ХХК-ийн 345 айлын орон сууцны барилга	СХД, 4 дүгээр хороо	345	“ЮП” ХХК
12	Иргэн Д.Бямбасүрэнгийн 110 айлын үйлчилгээтэй орон сууц	СХД, 15 дугаар хороо	110	Иргэн Д.Бямбасүрэн, “Биляг орд констракшн” ХХК
13	“Хос багана” орон сууцны хотхон	СХД, 18 дугаар хороо	144	“Эх ачуут” ХХК
14	“Номтын ам” ХХК-ийн 240 айлын орон сууцны барилга	СХД, 19 дүгээр хороо	240	“Номтын ам” ХХК
15	80 айлын орон сууцны барилга	СБД, 19 дүгээр хороо	80	“Дулааны IY цахилгаан станц” ТӨХК
<b>СҮХБААТАР ДҮҮРЭГ</b>				
16	57 айлын үйлчилгээтэй орон сууцны барилга	СБД, 10 дугаар хороо	57	“Мөнгөн тулга цамхаг” ХХК
<b>НАЛАЙХ ДҮҮРЭГ</b>				
17	“Налгар” хотхон (I ээлж)	НД, 7 дугаар хороо	48	“Дөлгөөн дөл” ХХК
<b>ХАН-УУЛ ДҮҮРЭГ</b>				
18	Ажилчдын 240 айлын орон сууцны барилга	ХУД, 2 дугаар хороо	240	Эрчим хүчний газар, “Тэнгэр апат” ХХК
19	УБЦТС, ТБЦДС ТӨХК-ийн ажилчдын 594 айлын орон сууцны барилга	ХУД, 3 дугаар хороо	594	“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК
20	“Модун” ХХК-ийн 164 айлын орон сууцны барилга	ХУД, 10 дугаар хороо	164	“Модун” ХХК
21	15 айлын орон сууцны барилга	ХУД, 10 дугаар хороо	15	“Жигүүрт хөсөг” ХХК
22	Онцгой байдлын албаны алба хаагчдын орон сууц	ХУД, 10 дугаар хороо	72	Онцгой байдлын ерөнхий газар



23	45 айлын орон сууцны барилга	ХУД, 15 дугаар хороо	45	“Оюуны зураг” ХХК
	ДҮН		3245	
<b>БҮСИЙН ТУЛГУУР ТӨВ БОЛОН АЙМГИЙН ТӨВ</b>				
<b>ДАРХАН-УУЛ АЙМАГ</b>				
24	Иргэн Ц.Бат-Эрдэнийн 50 айлын орон сууцны барилга	Дархан сум, 13 дугаар баг	20	Иргэн Ц.Бат-Эрдэнэ, “Жаанаар” ХХК
25	20 айлын орон сууцны барилга	Дархан сум, 14 дүгээр баг	20	“Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК
26	“Ногоон хүрээлэн” орон сууцны хотхон	Дархан сум, 15 дугаар баг	156	Иргэн Ш.Ариунболд “Түшигт арга конструкшн” ХХК
<b>ДОРНОГОВЬ АЙМАГ</b>				
27	“Нарлаг шанд” орон сууцны бичил хороолол (I эзлж)	Сайншанд сум, 2 дугаар баг	92	“Нэгдсэн монгол” ХХК
28	Дорноговь аймгийн ЗДТГ-ын ажилчдын 60 айлын орон сууцны барилга	Сайншанд сум, 3 дүгээр баг	60	Дорноговь аймгийн ЗДТГ, “Берилл билд” ХХК
<b>ЗАВХАН АЙМАГ</b>				
29	Онцгой байдлын хэлтсийн 20 айлын орон сууцны барилга	Улиастай сум, Богдын гол баг	20	Завхан аймгийн Онцгой байдлын хэлтэс
<b>ОРХОН АЙМАГ</b>				
30	63 айлын орон сууцны барилга	Баян-Өндөр сум, Зээст баг	63	Орхон аймгийн Үйлдээрчийн эвлэлийн холбоо, “М энд Б конструкшн” ХХК
31	“Залуус” хотхоны 60 айлын орон сууцны барилга	Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг	60	“Анж андууд” ХХК
<b>СЭЛЭНГЭ АЙМАГ</b>				
32	“Жаргалан” хотхоны 96 айлын орон сууцны барилга	Мандал сум, 1 дүгээр баг	96	“Тун жөү” ХХК
<b>ТӨВ АЙМАГ</b>				
33	Үйлчилгээний төвтэй, орон сууцны барилга	Зуунмод сум, 1 дүгээр баг	56	“Содоко” ХХК
<b>ХОВД АЙМАГ</b>				
34	35 айлын орон сууцны барилга	Жаргалант сум, Цамбагарав баг	35	“Оюу мандал” ХХК
35	“Ховд” хороолол	Жаргалант сум, Бугат баг	456	Ховд аймгийн ЗДТГ, Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

УВС АЙМАГ				
36	16 айлын орон сууцны барилга	Улаангом сум, 3 дугаар баг	16	“Баянцагаан зам” ХХК
37	Төрийн албан хаагчдын 30 айлын орон сууц	Улаангом сум	30	Увс аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ДҮН		1180		
НИЙТ		4425		

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 209

Улаанбаатар  
хот

### Гэр хороолллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хот болон төв, суурин газрын гэр хороололд амьдарч байгаа иргэдийн усны үйлчилгээний үнийг тухайн орон нутгийн орон сууцанд амьдарч буй иргэдийн төлж байгаа хэмжээнд хүртэл бууруулах саналыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах зөвлөлд тавьж, шат дараатайгаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатарт даалгасугай.

2. Одоо мөрдөгдөж байгаа усны үйлчилгээний төлбөрийг бууруулснаар ус ханган нийлүүлэгч байгууллагад 2012 онд үүсэх алдагдлыг тооцон санхүүгийн эх үүсвэрийг нь шийдвэрлэхийг Сангийн сайд Д.Хаянхярваад, цаашид жил бүр орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Д.ЦОГТБААТАР**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 210

Улаанбаатар  
хот

### Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолоор тогтоосон хилийн заагтай давхацсан алтны шороон ордын 124 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэхэмжилсэн нөхөх олговорт болон тусгай зөвшөөрлийн талбайд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн аудит хийлгэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Д.Хаянхярваа, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.

2. Хөндлөнгийн аудит хийлгэхэд болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд нөхөх олговор олгоход шаардагдах хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг Сангийн сайд Д.Хаянхярваад даалгасугай.

3. Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолоор тогтоосон хилийн заагтай давхцаж, тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан алтны 92 шороон ордын нөхөн сэргээлт хийх ажилд хяналт тавьж, хүлээн авахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүү болон холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЭРДЭС БАЯЛАГ,  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

Д.ЗОРИГТ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 212

Улаанбаатар  
хот

### Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2003 оны 164 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрэм”-ийн Дөрөвдүгээр зүйлд дор дурдсан агуулга бүхий 4.5 дахь заалт нэмсүгэй:

“4.5. Өмнөх давааны барилдаан дуусч, тухайн бөхийг ам авч барилдахаар зарласнаас хойш ам авах хугацаа 5 минутаас илүүгүй байна. Тогтоосон хугацаанд ам аваагүй бол цолны эрэмбээр дараагийн бөх авна.”

2. Мөн дүрмийн 3.2 дахь заалтыг “Улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд ослын даатгалд даатгуулсан, 18-аас дээш насны бөхийг барилдуулна.” гэж өөрчлөн найруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**М.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2012 оны 6 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 214

Улаанбаатар  
хот

#### **Зарлагын хязгаарыг батлах тухай**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014-2015 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2013 оны төсвийн орлогын доод хязгаар, төсвийн зарлагын дээд хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2013 оны төсвөө боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**САНГИЙН САЙД**

**Д.ХАЯНХЯРВАА**



Засгийн газрын 2012 оны 214 дүгээр  
тогтоолын хавсралт

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАХИРАГЧ НАРЫН  
2013 ОНЫ ТӨСВИЙН ХЯЗГААР

(сая төгрөг)

Төсвийн ерөнхийлөн захирагч		2012 оны төсвийн тодотгол	2013 оны төсвийн хязгаар
<b>УЛСЫН ТӨСӨВ</b>			
<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА</b>			
I	1 Төсвийн орлогын дүн	20.0	20.0
	1.1 Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2 Төсвийн байгууллагын өөрийн орлого	20.0	20.0
	2 Суурь зарлагын дүн	6,228.2	5,144.3
	2.1 Ургсгал зардал	5,028.5	5,144.3
	2.2 Хөрөнгийн зардал	1,199.7	-
	2.3 Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА</b>			
II	1 Төсвийн орлогын дүн	100.0	100.0
	1.1 Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2 Төсвийн байгууллагын өөрийн орлого	100.0	100.0
	2 Суурь зарлагын дүн	18,427.3	18,780.3
	2.1 Ургсгал зардал	17,282.3	17,625.7
	2.2 Хөрөнгийн зардал	1,145.0	-
	2.3 Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
	2.4 Гадаад зээлээс санхүүжих зардал		1,154.6
<b>МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦҮЙН ДАРГА</b>			
III	1 Төсвийн орлогын дүн	0.0	0.0
	1.1 Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2 Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-
	2 Суурь зарлагын дүн	584.0	507.0
	2.1 Ургсгал зардал	533.8	507.0
	2.2 Хөрөнгийн зардал	50.2	-
	2.3 Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ</b>			
IV	1 Төсвийн орлогын дүн	0.0	0.0
	1.1 Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2 Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-
	2 Суурь зарлагын дүн	1,904.0	12,116.8
	2.1 Ургсгал зардал	1,711.0	2,116.8
	2.2 Хөрөнгийн зардал	193.0	10,000.0
	2.3 Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА</b>			
	1 Төсвийн орлогын дүн	10.0	10.0

Y	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	10.0	10.0
	2	Суурь зарлагын дүн	20,630.9	50,346.7
	2.1	Ургал зардал	18,840.7	40,809.1
	2.2	Хөрөнгийн зардал	1,790.2	9,537.6
	2.3	Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-
	<b>УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР</b>			
YI	1	Төсвийн орлогын дүн	0.0	0.0
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-
	2	Суурь зарлагын дүн	18,525.5	24,294.5
	2.1	Ургал зардал	13,402.2	16,894.5
	2.2	Хөрөнгийн зардал	5,123.3	7,400.0
	2.3	Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-
YII	<b>ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА</b>			
	1	Төсвийн орлогын дүн	0.0	0.0
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-
	2	Суурь зарлагын дүн	1,416.7	1,534.9
	2.1	Ургал зардал	1,352.2	1,534.9
	2.2	Хөрөнгийн зардал	64.5	-
YIII	2.3	Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-
	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД</b>			
	1	Төсвийн орлогын дүн	523,392.1	32,052.1
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	512,257.3	21,202.3
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	11,134.8	10,849.8
	2	Суурь зарлагын дүн	96,954.4	684,391.7
	2.1	Ургал зардал	38,130.1	51,350.2
IX	2.2	Хөрөнгийн зардал	58,824.3	64,293.0
	2.3	Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-
	3	Бодлогын нөөц	-	568,748.5
	<b>МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД</b>			
	1	Төсвийн орлогын дүн	8,826.2	7,916.7
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	2,226.0	1,316.6
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	6,600.2	6,600.2
X	2	Суурь зарлагын дүн	133,875.6	104,330.8
	2.1	Ургал зардал	78,916.5	83,200.8
	2.2	Хөрөнгийн зардал	54,959.1	21,130.0
	2.3	Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-
	<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА</b>			
	1	Төсвийн орлогын дүн	1,389.2	1,389.2
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	1,389.2	1,389.2
	2	Суурь зарлагын дүн	51,617.1	20,688.8



	2.1	Ургал зардал	14,783.2	15,422.3
	2.2	Хөрөнгийн зардал	36,833.9	5,266.5
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД</b>				
XI	1	Төсвийн орлогын дүн	17,946.6	22,208.7
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	16,970.6	21,232.7
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	976.0	976.0
	2	Суурь зарлагын дүн	38,696.1	61,624.5
	2.1	Ургал зардал	29,680.1	32,142.0
	2.2	Хөрөнгийн зардал	9,016.0	29,482.5
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>САНГИЙН САЙД</b>				
XII	1	Төсвийн орлогын дүн	4,122,042.6	6,021,363.7
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	3,515,311.9	5,687,436.8
	1.1.1	Үүнээс: Тогтвортжуулалтын сан	322,445.4	333,926.9
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-
	2	Суурь зарлагын дүн	448,286.4	1,084,186.7
	2.1	Ургал зардал	459,144.3	585,957.9
	2.2	Хөрөнгийн зардал	48,138.0	360,254.8
<b>ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД</b>				
XIII	1	Төсвийн орлогын дүн	17,578.7	9,440.4
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	13,197.5	2,678.4
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	4,381.2	4,319.0
	1.3	НДС-гаас улсын эмнэлгүүдэд олгох	-	2,443.0
	2	Суурь зарлагын дүн	306,040.6	292,709.1
	2.1	Ургал зардал	282,960.6	300,402.1
	2.2	Хөрөнгийн зардал	45,257.1	14,484.1
<b>БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД</b>				
XIV	1	Төсвийн орлогын дүн	3,782.5	147.8
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	3,634.7	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	147.8	147.8
	2	Суурь зарлагын дүн	102,728.1	81,863.4
	2.1	Ургал зардал	68,723.5	72,877.8
	2.2	Хөрөнгийн зардал	34,004.6	8,985.6
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД</b>				
XY	1	Төсвийн орлогын дүн	17,661.9	23,529.1
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	17,661.9	21,287.6
	1.3	НДС-гаас улсын эмнэлгүүдэд олгох	-	2,241.4
	2	Суурь зарлагын дүн	166,158.6	176,988.8

	2.1	Ургал зардал	149,892.3	165,488.6
	2.2	Хөрөнгийн зардал	16,266.3	11,500.2
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД</b>				
XYI	1	Төсвийн орлогын дүн	9,128.6	9,128.6
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	9,128.6	9,128.6
	2	Суурь зарлагын дүн	1,158,089.7	1,234,087.5
	2.1	Ургал зардал	931,905.5	1,090,055.9
	2.2	Хөрөнгийн зардал	216,602.9	121,016.8
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	9,581.3	9,581.3
	2.4	Гадаад зээлээс санхүүжих зардал	-	13,433.5
	<b>ЗАМ ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД</b>			
XYII	1	Төсвийн орлогын дүн	59,158.4	75,395.1
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	58,550.9	74,787.6
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	607.5	607.5
	2	Суурь зарлагын дүн	767,768.1	1,028,059.8
	2.1	Ургал зардал	33,232.8	30,649.4
	2.2	Хөрөнгийн зардал	734,535.3	556,576.6
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
	2.4	Гадаад зээлээс санхүүжих зардал	-	440,833.8
	<b>ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД</b>			
XYIII	1	Төсвийн орлогын дүн	115,442.5	176,625.8
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	114,709.1	175,892.4
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	733.4	733.4
	2	Суурь зарлагын дүн	235,104.0	338,522.7
	2.1	Ургал зардал	53,296.7	55,623.3
	2.2	Хөрөнгийн зардал	176,344.6	253,617.7
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	5,462.7	-
	2.4	Гадаад зээлээс санхүүжих зардал	-	29,281.7
	<b>НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД</b>			
XIX	1	Төсвийн орлогын дүн	64,011.1	65,034.1
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	5,529.0	6,426.3
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	58,482.1	58,482.1
	1.3	НДС-гаас улсын эмнэлгүүдэд олгох	-	125.8
	2	Суурь зарлагын дүн	685,383.5	816,756.4
	2.1	Ургал зардал	641,170.3	789,323.4
	2.2	Хөрөнгийн зардал	44,213.2	3,433.0
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	24,000.0
	<b>ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД</b>			
XX	1	Төсвийн орлогын дүн	65,989.0	65,989.0
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	65,989.0	65,989.0
	2	Суурь зарлагын дүн	240,071.7	279,251.8



	2.1	Ургсгал зардал	100,703.6	101,243.7
	2.2	Хөрөнгийн зардал	132,250.8	66,335.6
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	7,117.2	5,074.0
	2.4	Гадаад зээлээс санхүүжих зардал	-	106,598.5
<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД</b>				
XXI	1	Төсвийн орлогын дүн	111,561.8	111,669.9
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	9,419.2	9,419.2
	1.3	НДС-гаас улсын эмнэлгүүдэд олгох	102,142.6	102,250.7
	2	Суурь зарлагын дүн	506,469.0	529,345.4
	2.1	Ургсгал зардал	382,921.5	425,042.0
	2.2	Хөрөнгийн зардал	123,547.4	56,775.0
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
	2.4	Гадаад зээлээс санхүүжих зардал	-	47,528.3
<b>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА</b>				
XXII	1	Төсвийн орлогын дүн	0.0	35.4
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	35.4
	2	Суурь зарлагын дүн	542.8	664.3
	2.1	Ургсгал зардал	502.6	664.3
	2.2	Хөрөнгийн зардал	40.2	-
XXIII	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА</b>				
1	Төсвийн орлогын дүн	0.0	0.0	
1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-	
1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-	
2	Суурь зарлагын дүн	19,405.6	14,623.2	
2.1	Ургсгал зардал	19,387.8	14,623.2	
XXIV	2.2	Хөрөнгийн зардал	17.8	-
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>ХҮННИЙ ЭРХХИЙН ҮНДЭСЧИЙ КОМИССЫН ДАРГА</b>				
1	Төсвийн орлогын дүн	0.0	0.0	
1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-	
1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-	
2	Суурь зарлагын дүн	467.6	474.4	
2.1	Ургсгал зардал	462.6	474.4	
XXV	2.2	Хөрөнгийн зардал	5.0	-
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР</b>				
1	Төсвийн орлогын дүн	0.0	0.0	
1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-	
1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-	
2	Суурь зарлагын дүн	1,374.1	1,347.3	
	2.1	Ургсгал зардал	1,299.1	1,347.3

	2.2	Хөрөнгийн зардал	75.0	-
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА</b>				
XXVI	1	Төсвийн орлогын дүн	600.0	660.0
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	600.0	660.0
	2	Суурь зарлагын дүн	1,657.5	2,218.8
	2.1	Ургал зардал	1,407.5	2,218.8
	2.2	Хөрөнгийн зардал	250.0	-
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА</b>				
XXVII	1	Төсвийн орлогын дүн	14.4	14.4
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	14.4	14.4
	2	Суурь зарлагын дүн	5,969.3	5,272.8
	2.1	Ургал зардал	5,175.9	5,272.8
	2.2	Хөрөнгийн зардал	793.4	-
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА</b>				
XXVIII	1	Төсвийн орлогын дүн	0.0	0.0
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-
	2	Суурь зарлагын дүн	890.3	865.4
	2.1	Ургал зардал	857.3	865.4
	2.2	Хөрөнгийн зардал	33.0	-
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ЗАХИРАЛ</b>				
XXIX	1	Төсвийн орлогын дүн	0.0	0.0
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-
	2	Суурь зарлагын дүн	7,833.7	6,333.7
	2.1	Ургал зардал	6,333.7	6,333.7
	2.2	Хөрөнгийн зардал	1,500.0	-
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА</b>				
XXX	1	Төсвийн орлогын дүн	0.0	0.0
	1.1	Төсөвт төвлөрүүлэх	-	-
	1.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-
	2	Суурь зарлагын дүн	8,256.4	7,660.5
	2.1	Ургал зардал	7,168.3	7,660.5
	2.2	Хөрөнгийн зардал	1,088.1	-
	2.3	Эргэж төлөгдхөн цэвэр зээл	-	-
<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>				
		НИЙТ ОРЛОГЫН ДҮН	5,138,655.5	6,288,803.1
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>				
		НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	5,051,356.8	6,884,992.2



ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСӨВ				
I	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД			
	1 Төсвийн орлогын дүн	110,000.0	70,000.0	
II	САНГИЙН САЙД			
	1 Төсвийн орлогын дүн	364,638.1	524,530.4	
III	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД			
	2 Суурь зарлагын дүн	787,133.6	64,874.9	
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	474,638.1	594,530.4	
	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	787,133.6	64,874.9	
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ				
	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД			
XIX	1 Төсвийн орлогын дүн	970,411.0	1,148,354.7	
	2 Суурь зарлагын дүн	883,903.2	1,055,293.6	
	2.1 Үргсгал зардал	880,088.9	1,049,819.2	
	2.2 Хөрөнгийн зардал	3,814.3	5,474.4	
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	970,411.0	1,148,354.7	
	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	883,903.2	1,055,293.6	

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 218

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын иргэнд давуу эрхийн хувьцаа эзэмшүүлэх тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 8.4, 8.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн нэг ширхэг давуу эрхийн хувьцааг хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэн бүрт үнэ төлбөргүйгээр эзэмшүүлсүгэй.

2. Хувьцаа эзэмших иргэдийн эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, хаягийн бүртгэлийн мэдээллийг гэрээний үндсэн дээр “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д шилжүүлж байхыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Л.Амарсанаад даалгасугай.

3. Жил бүрийн хүн амын өсөлтийг харгалзан “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн давуу эрхийн хувьцаа нэмж гаргах асуудлыг тухай бур зохих журмын дагуу шийдвэрлэж байхыг Төрийн өмчийн хороо (Б.Заяабал), “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлдүүрэг болгосугай.

4. “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг хөтлөх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн гүйцэтгэх захирал Я.Долгоржав, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Гандулам нарт үүрэг болгосугай.

5. Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн нэгдсэн санд шинээр төрсөн болон нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан иргэний мэдээллийг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон дараа сарын 5-ны дотор “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д хүргүүлж байхыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Л.Амарсанаа, өөрчлөлт орсон мэдээллийн дагуу компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулж байхыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Гандулам нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЭРДЭС БАЯЛАГ,  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

**Д.ЗОРИГТ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medeel@parliament.mn

**Утас:** 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 1.25

**Индекс:** 14003